



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26-44-44, Факс: (976-11) 32-90-84,
E-mail: info@frc.mn, <http://www.frc.mn>

2022.07.19 № ЦАТ-11/01/007 .

танай 2022.06.09 -ны № 09 -Т

Хаяг, байршлын өөрчлөлтийг
бүртгэсэн тухай

Санхүүгийн Зохицуулах Хорооны 2020 оны 120 дугаар тогтоолоор баталсан “Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрх олголт, бүртгэлийн журам”-ын дагуу танай хаяг байршлын өөрчлөлтийг бүртгүүлэх тухай хүсэлтийг хянаж “Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 5-р хороо, 6-р хороолол, Оранж плаза, 406 тоот” хаягт бүртгэлтэй байсныг “Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 7-р хороо, 11-р хороолол, Эрхүүгийн гудамж, 10б дугаартай барилга, 2 давхар” гэж шинэчлэн бүртгэсэн болно.

Компанийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.5-д "Компанийн хаягийн өөрчлөлтийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд заасны дагуу бүртгэх байгууллагад бүртгүүлнэ", Хорооны 2020 оны 120 дугаар тогтоолоор баталсан журмын 6.9-д "Хаягийн өөрчлөлтийг бүртгэсэн бол тухайн зохицуулалттай этгээдийн тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хавсралтад холбогдох тэмдэглэгээг хийнэ" гэж заасны дагуу улсын бүртгэлийн гэрчилгээнд хаягийн өөрчлөлтийг даруй хийлгэж Хорооны тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хавсралтад дээрх хаягийн өөрчлөлтийн тэмдэглэгээг хийлгэнэ үү.

Компанийн хаяг, байршил өөрчлөгдсөнтэй холбоотойгоор харилцагч, үйлчлүүлэгчдэд сөргөөр нөлөөлөхгүй, төөрөгдүүлэхгүй байх талаар анхаарч ажиллахыг хүсье.

